



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/530

Есөнбулаг

Ахмадын өдөрт зардал гаргах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 34 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмадын өдрийг тохиолдуулан Есөнбулаг сумын ахмад настнуудын дунд зохион байгуулах уралдаан тэмцээний шагналд зардал гаргасугай.

2. Шаардагдах 2,450,000 (хоёр сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



